



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 06 сарын 08 өдөр

Дугаар А/370

Номгон

Түргэвчилсэн оношлуурын нөөц
бүрдүүлэхэд хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын "Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай" хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5-ын "в", Гамшгаас хамгаалах тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.4, 32 дугаар зүйлийн 32.1.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1.5, Засгийн газрын 2020 оны "Журам шинэчлэн батлах тухай" 133 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Гамшгаас хамгаалах дотоодын хүмүүнлэгийн тусламжийг зохицуулах журам", Онцгой комиссын 2021 оны 46 дугаар хурлын тэмдэглэлийг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1.Аймгийн Онцгой комиссоос цаг үеийн нөхцөл байдалтай холбогдуулан авч хэрэгжүүлж буй арга хэмжээний хүрээнд коронавирусын халдвар илрүүлэх түргэвчилсэн оношлуурын нөөц бүрдүүлэх зардалд **85,000,000** (Наян таван сая) төгрөгийг аймгийн Онцгой комиссын Дотоодын хандив, тусламжийн мөнгөн хөрөнгийн зардлаас санхүүжүүлсүгэй.

2.Аймгийн Онцгой комиссын Дотоодын хандив, тусламжийн мөнгөн хөрөнгийн зардлаас гарах зардлын тооцоог хавсралтаар баталсугай.

3.Холбогдох зардлыг дотоодын хандив, тусламжаас санхүүжүүлэхийг Дотоодын хүмүүнлэгийн тусламжийг хүлээн авах, хуваарилах ажлын хэсэг (С.Байгалмаа)-т зөвшөөрсүгэй.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Онцгой байдлын газар, Онцгой комиссын орлогч дарга (хурандаа Ж.Алтангэрэл)-д даалгасугай.

ДАРГА



Д.МӨНХСАЙХАН

621010935

Аймгийн Засаг даргын 2021 оны 06 дугаар
сарын 08-ны өдрийн А/370 дугаар
захирамжийн хавсралт

АЙМГИЙН ОНЦГОЙ КОМИССЫН ДОТООДЫН ХАНДИВ
ТУСЛАМЖИЙН МӨНГӨН ХӨРӨНГӨӨС ГАРАХ ЗАРДЛЫН
ТООЦОО

№	Зардлын зүйл	Зориулалт	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ
1	Ковид-19 түргэвчилсэн оношлуур	Аймгийн Онцгой комисст түргэвчилсэн оношлуурын нөөц бүрдүүлэх	ширхэг	5000	17,000	85,000,000
НИЙТ ЗАРДЛЫН ДҮН						85,000,000

_____оОо_____